

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ	MNS 5973:2009
The size of green facilities (garden) and its distance in construction planning and engineering infrastructure development	

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын бүх шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

1.1 Барилга, инженерийн байгууламж, зам харгуйн ойролцоох ногоон байгууламжийг төлөвлөх, зураг төсөл зохиох, цэцэрлэгжүүлэх, барьж байгуулах, тэдгээрийг хүлээн авахад тавих шаардлагуудыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөх, барьж байгуулахад ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээг тогтоож, хэрэгжүүлэхэд мөрдөнө.

3. Норматив ишлэл

Энэ стандартад хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД болон холбогдох хууль тогтоомжийг иш татсан болно.

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1. Гувар

Модны үндэсний хүзүүнээс дээш газрын ил байгаа ишний титэмгүй хэсгийг хэлнэ

4.2. Ногоон байгууламж

Мод сөөг суулгаж цэцэг болон олон наст ургамал тарьж ургуулсан талбайг хэлнэ

4.3. Инженерийн шугам сүлжээ

Газрын дээрх болон доорх шугам сүлжээ (дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, холбоо г.м.)

5. Техникийн шаардлага

5.1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээг дараах хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байвал зохино.

Хүснэгт

д/д	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээний тэнхлэг	
		Шилмүүст болон навчит модны гувар, ишний тэнхлэг хүртэл (метр)	Бут сөөг, сөөгөнцөрийн гол хүртэл (метр)
1	Барилга байгууламжийн гадна хананаас	5.0	2.0
2	Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлагын захаас	1.0	0.7
3	Авто машин, троллейбусны замын зах, хашлаганаас	1.5	0.6
4	Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
5	Түшиг ханын дотоод ирмэг буюу улнаас	1.5	0.6
6	Цамхаг ба тавцангийн баганын голоос	2.0	1.0
7	2 метр ба түүнээс өндөр хашааны хананаас	4.0	1.0
8	Газар дээрх болон доорх шугам сүлжээнээс Үүнд:		
	а) Дулаан дамжуулах яндан хоолойноос	3.0	3.0
	б) Цэвэр, бохир усны яндан хоолойноос	3.0	3.0
	в) Цахилгаан дамжуулах кабель утаснаас	2.5	2.0
г) Троллейбусны болон гэрлийн шонгоос	5.0	2.0	
9	Таримал мод, ургамлын:	3.0-4.0	0.7-1.5
	а) Ургамал хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5
	б) Эгнээ хоорондын зай	2.5-4.0	1.0-1.5
	в) Сөөлжлөн суулгасан эгнээ хоорондын зай		

5.2. Шинээр төлөвлөгдсөн барилга байгууламжийн нийт талбайн 20-оос доошгүй хувийг ногоон байгууламж байхаар ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

ТӨГСӨВ.